

“Монноос” ХК-ийн 2017 оны
үйл ажиллагааны тайлан

Илтгэгч: Гүйцэтгэх захирал

Х.Эрдэнэбаяр

“Монноос” ХК нь 2017 онд үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд ноосны агуулахууд болон дулаан, цахилгаан, цэвэр, бохир үсны шугам бүхий үйлдвэрлэл, оффисын байр талбайнууд болон гаднах зам, талбайг түрээслэх үйл ажиллагааг явууллаа.

1. “Монноос” ХК-ийн түрээсийн үйл ажиллагаа

- 2.1. Хүйтэн агуулах, инженерийн шугам сүлжээ бүхий оффис, үйлдвэрлэлийн байр, гаднах зам, талбайг түрээслэх замаар 2017 онд НӨАТ орсон дүнгээр нийт 125,3 сая төгрөгийн орлого оллоо. “Монноос” ХК-ийн үйл ажиллагааны орлого ба зарлагыг сүүлийн 6 жилийн байдлаар харьцуулан харуулбал:

№	Он	Нийт орлого/мян төг/	Нийт зардал /мян төг/	Ашиг (алдагдал) /мян төг/
1	2011	26683.3	51458.8	(24775.5)
2	2012	61603.2	83117.5	(21514.3)
3	2013	120356.4	114521.5	6834.9
4	2014	160552.0	151711.0	8823.2
5	2015	135600.0	131500.0	4100.0
6	2016	102251.8	101567.7	684.2
7	2017	128847.1	125007.4	3800.0

- 2.2. Хонины бохир ноосыг Улаанбаатар хотод оруулахгүй байх Төр засгийн шийдвэрээс болж бохир ноос хадгалах түрээсийн үйл ажиллагаанд хүндрэл гарсан боловч тус компани нь 2017 онд нийт 14-н аж ахуйн нэгж хувь хүмүүстэй түрээсийн гэрээг байгуулж ажилласан байна. Сул байсан 620 m^2 агуулахын байр болон 50 m^2 дулаан байрыг түрээслэсэн болно.
- 2.3. Одоогийн байдлаар мал эмнэлэгийн ба зоорины зориулалт бүхий хүйтэн байрыг түрээслэж чадаагүй байна.
- 2.4. “Монноос” ХК-ийн 1470 m^2 хүйтэн агуулахын байрны дээврийн засварыг 33075.0 мян төгрөгийн өртөг бүхий резинэн давхраг бүхий материалыар бүрж ус гоождоггүй болгох ажлын үр дүнд дээврийн засварын зардалыг уг 1470 m^2 хүйтэн агуулахын түрээсийн төлбөрөөс сутгах зарчмаар тооцон гүйцэтгүүлсэн болно. 2018 оны 5-р сарын 1-нээс эхлэн 1470m^2 талбайн түрээсийн төлбөрийг бодитоор авч эхлэнэ.
- 2.5. “Монноос” ХК-ийн задгай талбайд хязгаарлах хашааг бариулснаар “Монноос” ХК-ийн задгай талбайд хяналтгүй тээврийн хэрэгсэл болон хүний хөдөлгөөнийг хязгаарлаж чадлаа. (Уг хашаа нь Монноос ХК-ийн хөрөнгө болж үлдэхээр боллоо).
- 2.6. “Монноос” ХК-ийн хашаан дундуур явдаг засмал замын засварыг “АПУ” ХК нь өөрийн хөрөнгөөр 100% засварлаж байхаар боллоо.

Х.Эрдэнэбаяр

- 2.7. "Монноос" ХК нь түрээслэгч 14 компани, хувь хүнтэй дулаан, цахилгаан, ус, хог тээвэрлэлтийн болон түрээсийнхээ төлбөрийн тооцоог хийж төлбөрийг сар бүр нэхэмжилж хугацаанд нь хурааж компаний санхүүд тушаах ажлыг гүйцэтгэсэн байна.

3. 2017 онд хийгдсэн засвар үйлчилгээний ажлууд

- 3.1. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хурээнд төсөв гаргаж батлуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

Дулааны үзелд ялтсан бойлуурыг угаалгаж цэвэрлэсэн. Хуучирч муудсан шугам хоолойнуудыг гагнуулж сэргээн засварласан. Үзелийн цонхнуудыг битүүлж хаалтыг шинэчилсэн. КНС-ийн бохирыг ухуулж лагийг цэвэрлэж асуулсан. Нийт шугам хоолойг ф100-ийн хос 2 шугам, ф40-ийн шугам хоолой 20метр, ф20-ийн хаалт 1ш тус тус шинээр сольсон Бойлорын ажлын дугуйг гагнуулж сэргээн засуулсан. Нийт 2,826,600 төгрөгийн засвар үйлчилгээг хийсэн.

- 3.2. Цэвэр усны шугамын тоолуур дулааны үзелийн даралтын манометр болон хэмжих хэрэгслийдийг шалгуулж, баталгаажуулж гэрээнүүдийг сунгасан.
- 3.3. Цэвэр бохир усны үзелд техникийн үзлэг шалгалт хийж ил байгаа цахилгааны шугамын утаснуудыг монтажилж шинэчилэн сольсон.
- 3.4. Түрээслэгч байгууллагудын цахилгаан зарцуулалтанд үзлэг шалгалт хийж 2 байгууллагын цахилгаан самбар шинээр солиуж баталгаажуулсан.
- 3.5. Сар бүр хэрэглэгч байгууллагудтай дулаан, цахилгаан усны тооцоо болон төлбөрийг нэхэмжлэж хурааж авах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- 3.6. УБДС ТӨХК-д ялтсан бойлуурын төлбөр 4,200,000 төгрөг төлсөн.
- 3.7. Монноос ХК-ний нийт $44,800\text{m}^2$ эзэмшил газрыг 5 хувааж тус бүрт нь газрын гэрчилгээ болон гэрээг хийж эх хувиар нь авсан. Мөн Чингис Хаан Банкинд зээлийн гэрээг шинэчилэн хийсэн.(Нийт төлбөр – 9,790,676 төгрөг)
- 3.8. Засмал зам ашиглан харуулын байрны гадна талаар шон босгож, трасс татааж тэмдэг тэмдэглэгээг хийлгэсэн.

4. Бусад

- 4.1. Монноос ХК нь 4 ажилтанг (Гурван манаач, ер.менежерийн туслах) бүтэн тарифаар 100%; 2 ажилтанг (ер.менежер болон ня-бо)-г хагас тарифаар цалинжуулан нийт 7 хүний бүтэц бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Тус компаний сарын цалингийн сан нь 2.0 сая төгрөг байна.
- 4.2. Монноос ХК-ийн ХУД-ийн 15-р хороонд байрлах 4.0га эзэмшил газрыг 5 хувааж тус бүрд нь кадастрын зургыг хийлгэн Нийслэлийн ЗД-ийн захирамж гаргуулж гэрээ, гэрчилгээг тус бүрд нь шинэчилж авсан болно .
- 4.3. Нисэх дэх газрын гэрчилгээг сунгасан болно.
- 4.4. Хан-Уул дүүргийн татварын хэлтэс нь Монноос ХК-ийн үл хөдлөх хөрөнгийн татварын хуримтлагдсан өр болох 106.4 сая төгрөгийг Монноос ХК-аас гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Шүүхийн шийдвэрээр 82,5 сая төгрөгийг төлөх болсон байна.

Х/27

5. 2017 оны Монноос ХК-ийн үйл ажиллагааны өрөнхий дүгнэлт

- 5.1. Монноос ХК нь агуулахын зориулалттай барилга байгууламж түүний инженерийн шугам сүлжээг бүрэн бүтэн байлгаж түрээслэх боломжоор хангаж байхын тулд хэт хуучирсан инженерийн шугам сүлжээ, хоолойнуудад хэсэгчилсэн засвар үйлчилгээг байнга хийж байсны үр дүнд 2017 нийт 125.1 сая төгрөгийн түрээсийн орлого оллоо. Улаанбаатар хотод бохир хонины ноос оруулахгүй болсон мөн Монгол улсад нүүрлэсэн эдийн засгийн хямралт байдлаас шалтгаалан зарим түрээслэгч компаниуд үйл ажиллагаагаа зогсоож гэрээгээ цуцалсан, үргэлжлүүлэн түрээслэж буй компаниуд түрээсийн төлбөрийг хувааж өгөх, хугацааг хойшлуулах гэх мэтээр хүндрэл гарч байсан ч гэсэн Монноос ХК-ийн гүйцэтгэх удирдлага өөрийн өмнө хүлээсэн Монноос ХК-ийн эзэмшил газар болон түүн дээрх үл хөдлөх хөрөнгийг алдахгүй хамгаалж, хадгалж тэдгээрийг түрээслэн тодорхой хэмжээний орлого оллоо.
- 5.2. 2017 онд хийхээр төлөвлөж байсан доорхи ажлуудыг санхүүжилтээс шалтгаалан хийж чадсангүй. Үүнд:
 - 8 давхар оффисын байрны дээврийн засварыг хийгээгүй
 - Нисэх дэхь аж ахуйн зориулалттай газрын хашааны дутуу хэсгийг гүйцээж бариагүй
 - Зоорь, мал эмнэлэг гэх мэт хүйтэн байруудыг түрээслэж чадсангүй

6. 2018 онд хийгдэх ажлын жагсаалт

- 6.1. Гэрээний хугацаа дуусч байгаа түрээслэгч компани, хувь хүмүүсийн гэрээг шинэчлэн хийх.
- 6.2. 8 давхар оффисын байрны дээврийн засварын төсөв гаргаж, засварыг ажил эхлүүлэх.
- 6.3. ХУД-ийн Нисэхд байрлах аж ахуйн зориулалттай газрын хашааны дутуу хэсгийг гүйцээж бариулах.
- 6.4. Ариг гал ХК-аас цахилгааны тэжээл авч ажиллах ажлын төсвийг хийж батлуулах.
- 6.5. Өвлийн бэлтгэл ажлаар муудсан шугам хоолойнуудыг сольж, засварлах
- 6.6. Блью Скай Хавтан ХХК-ний түрээсийн гэрээг шинэчлэн хийх.
- 6.7. ХЭРРО ХХК-ний агуулахын засварыг хийлгүүлж түрээсийн гэрээ байгуулах .
- 6.8. Үл хөдлөх хөрөнгийн татвар болох хуримтлагдсан өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэх .
- 6.9. Оффисын ба үйлдвэрлэлийн байрыг ашиглах асуудлыг шийдвэрлэх .

Гүйцэтгэх захирал

Х.Эрдэнэбаяр